# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр Дугаар 52 Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хулд сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 29,736,434 /хорин есөн сая долоон зуун гучин зургаан мянга дөрвөн зуун гучин дөрвөн/ төгрөгийн балансын үнэтэй, 22,302,325.62 /хорин хоёр сая гурван зуун хоёр мянга гурван зуун хорин таван төгрөг жаран хоёр мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй ДУЭ 51-11 улсын дугаартай UAZ 220695-355 маркийн фургон автомашиныг Сайхан-Овоо сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2 Хулд сумын Эрүүл мэндийн төвийн дарга (М.Доржханд), Сайхан-Овоо сумын Засаг даргын тамгын газрын дарга (С.Болоржаргал) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Сум, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хяналт дор хөрөнгө шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 10 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3 Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн
52 дугаар тогтоолын хавсралт

Хулд сумын Эрүүл мэндийн төвийн балансаас балансад шилжүүлэх тээврийн хэрэгслийн мэдээлэл

| № | Тээврийн хэрэгслийн төрөл | Марк | Улсын бүртгэлийн | | Үйлдвэрлэсэн он | Ашиглалтад орсон огноо | Тээврийн хэрэгслийн | | | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сери | Дугаар | | | Арлын дугаар | Моторын дугаар | Моторын эзлэхүүн /см3/ | | | | |
| 1 | Микробус | UAZ 220695-355 | ДУЭ | 51-11 | 2017 | 2017-03-29 | 220695H0404343 | 2693 | | | 29,736,434 | 22,302,325.62 | 7,434,108.38 |
| | **Хөрөнгийн дүн** | | | | | | | | | | **29,736,434 /хорин есөн сая долоон зуун гучин зургаан мянга дөрвөн зуун гучин дөрөв/ төгрөг** | **22,302,325.62 /хорин хоёр сая гурван зуун хоёр мянга гурван зуун хорин таван төгрөг жаран хоёр мөнгө/ төгрөг** | **7,434,108.38 /долоон сая дөрвөн зуун гучин дөрвөн мянга нэг зуун найман төгрөг гучин найман мөнгө/ төгрөг** |